



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 9 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 107


Улаанбаатар
хот

Төслийн нэгж байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 10.1.10, 17.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бүтээн байгуулалтын томоохон төслийг хэрэгжүүлэх зорилгоор нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төслийн нэгжийг 2016 оны III улиралд багтаан зохих журмын дагуу байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслийн нэгж болон одоо үйл ажиллагаа явуулж байгаа Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд

Ц.ДАШДОРЖ